

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Хуулийн этгээд нь дараахь тусгай зөвшөөрлүүдийг авна.

- *Цахилгаан үйлдвэрлэх*
- *Дулаан үйлдвэрлэх*
- *Цахилгаан дамжуулах*
- *Дулаан дамжуулах*
- *Диспетчерийн зохицуулалт хийх*
- *Цахилгаан түгээх*
- *Дулаан түгээх*
- *Эрчим хүчээр зохицуулалттай хангах*
- *Эрчим хүчээр зохицуулалтгүй хангах*
- *Цахилгаан импортлох, экспортлох*
- *Эрчим хүчний барилга байгууламж барих*

Сонирхогч хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлөө эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан дараахь баримтыг бүрдүүлнэ.

***Цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авахад
бүрдүүлэх баримт бичгийн агуулга***

1. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл

Өргөдлийг Хавсралт 11-д заасан маягийн дагуу гаргана.

2. Улсын бүртгэлийн гэрчилгээ

Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар батлуулж ирүүлнэ. Гэрчилгээнд байгууллага, компанийн тухай танилцуулгыг хавсаргах бөгөөд танилцуулгад байгууллага, компаний үүсэл хөгжил, үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, боловсон хүчний хангалт, өмчийн хэлбэр, эрхэлдэг тусгай зөвшөөрлийн бус үйл ажиллагааны төрлүүд зэргийн талаар тодорхой тусгасан байна.

3. Техник, эдийн засгийн үндэслэл

- тухайн байгууллага, компани нь тодорхой нутаг дэвсгэр, эзэмшлийн хүрээнд цахилгаан, дулаан үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх техник-эдийн засгийн боломж
- цахилгаан, дулаан үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхэлснээр олох орлого, зарлага, ашиг, өөрийн хэрэгцээ, алдагдал зэргийн талаар өнөөгийн түвшинд эдийн засгийн тооцоо судалгаа хийсэн байна.

4. Үйлдвэрлэх эрчим хүчний төрөл хэмжээ, чанарын үзүүлэлт

- үйлдвэрлэх цахилгаан, дулааны эрчим хүчний хэмжээ, тэдгээрийн чанарын үзүүлэлтүүд (хүчдлийн түвшин, давтамж, даралт, температур г.м.)
- эрчим хүчний хангамжийг техникийн шалтгаанаар сүүлийн 5 жилд тасалсан тоо, хязгаарласан эрчим хүчний хэмжээ
- дамжуулах, түгээх шугам сүлжээний цахилгаан, дулаан дамжуулах, түгээх чадлын хязгаар зэргийн талаар дэлгэрэнгүй судалгаа, мэдээлэл гаргана.

5. Үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт

Дараахь судалгаа, мэдээллийг гаргана. Үүнд:

- үндсэн болон туслах тоног төхөөрөмж, дэд өртөө, дулаан хуваарилах төв, насос станц зэргийн хүчин чадал, тоо, техникийн алдагдал (хүч чадлын түвшин бүрээр)
- үндсэн болон туслах тоног төхөөрөмж, шугам, дэд өртөө, дулаан хуваарилах төв, насос станц болон бусад тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын өнөөгийн байдал
- өөрийн хэрэгцээний бэлтгэл тэжээлийн тухай, АВР, бэлтгэл трансформатор, аваарийн бүртгэх төхөөрөмж, осциллографийн байдал, нөөц чадал,
- ашиглалт, засвар үйлчилгээнд хэрэглэх машин механизм, тоног төхөөрөмжийн судалгаа
- трансформатор, турбиний маслын нөөц, нүүрсийн хангамж, нүүрс буулгах, дамжуулах төхөөрөмж, галын аюулгүйн хангамж, тоос намжаах төхөөрөмж, тэдгээрийг цэвэрлэх төхөөрөмж,
- ус хангамжийн нөөц, хангамж, мэдээлэл, холбоо

6. Үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл

- цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээнд холбогдсон цэг, эзэмшлийн зааг ба эдгээрийг харуулсан зураг, схем
- цахилгаан, дулааныг үйлдвэрлэл, нийлүүлэлтийн баланс, тооцооны тоолуурын байршил, баталгаажуулсан баримт, зэргийн талаарх мэдээлэл, судалгаа

7. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Станц, дэд станцын орчин, радиаци, үнс, утаа зэрэг нь хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж буй эсэх талаар үнэлэлт өгсөн байна.

8. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэж байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж ирүүлнэ.

9. Санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи

Байгууллага, компаний санхүү, хөрөнгийн нөөц, чадавхи, эдийн засгийн үйл ажиллагаа, гадаад дотоодын зээл, өр, авлага, бэлэн мөнгөний нөөц зэргийн талаарх мэдээлэл, судалгаа

10. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага

Байгууллага, компанид эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр ажиллах ажилтнуудын мэргэжил, боловсрол, тухайн чиглэлээр ажилласан хугацаа, дадлага, туршлага, мэргэшсэн байдлын талаарх судалгаа, мэдээлэл

11. Барилга байгууламж эх үүсвэрийг байнгын ашиглалтад оруулах Улсын комиссын акт.

Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн агуулга

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ. /нотариатаар батлуулан хавсаргана./

Тусгайн компанийн танилцуулга байх бөгөөд түүнд үүсэл хөгжил, бүтэц зохион байгуулалт, өмчийн хэлбэр, эрхлэдэг үйл ажиллагааны төрлүүд, үйлчилгээний хүрээ, гаднын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хийгдэх байгаа буюу хийгдэхээр төлөвлөгдөж байгаа төслүүд, санхүү хөрөнгийн нөөц, өр авлага, эдийн засгийн үзүүлэлтүүдийг харуулсан схем зураг, хүснэгт маягтын хэлбэрээр хийж үйл ажиллагааны бусад онцлогуудыг тусгасан байна.

2. Техник, эдийн засгийн үндэслэлд дараахь зүйлийг заавал тусгасан байна.

а/ Диспетчерийн зохицуулалт хийх зайлшгүй шаардлага Үүнд:

- Эрчим хүчний систем
- Импорт, экспорт
- Жил сар, хоногийн ачааллын өөрчлөлт
- үйлдвэрлэгч хоорондын ба үйлдвэрлэгч - дамжуулагчдын хоорондын тооцоо
- аваарийг сэргээх
- хяналт тавих
- горим төлөвлөлтийн асуудал
- сэлгэн залгалт хийх г.м.

б/ диспетчерийн зохицуулалт хийх боломж

- техник хэрэгслэл, мэргэжлийн боловсон хүчин, программ хангамжийн жагсаалт
- хууль эрхийн актуудыг бүрдүүлсэн байдал
- Эрчим хүчний тухай хууль, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг судласан байдал

- Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан гэрээ хэлцлүүд г.м

в/ Диспетчерийн зохицуулалтын зардлын тооцоо

г/ ашиг, алдагдал

д/ Диспетчерийн зохицуулалт хийхэд цаашид тавих зорилт, оршиж

байгаа дутагдал

3. Эрчим хүч дамжуулахад ашиглах эрчим хүчний нөөцийн судалгаа

Энд цахилгааны хэсэгт гарсан аваарийн үед системийн чадлын дутагдлыг нөхөхийн тулд хаанаас хэдэн МВт-ын чадал байршуулан хадгалах талаар хийсэн гэрээг хавсаргана.

4. Эрчим хүчний төрөл хэмжээ, чанарын үзүүлэлт

- сүүлийн 5 жилийн болон хүлээгдэж байгаа 5 жилийн ЭХС-ийн чадал, хэрэглээний баланс
- үйлдвэрлэгч -дамжуулагч, дамжуулагч - түгээгчийн хооронд авсан, өгсөн цахилгааныг тооцох хэрэгслэл, тооцооны аргачлал, схем зургийн хамт гаргана.
- Системийн хүчдэлийн түвшинг тохируулах хэрэгслэл, хүчдэл тохируулах арга, дүрэм, журам, зааврыг хавсаргана.
- Системийн давтамж тохируулахтай холбогдсон заавар, давтамж тохируулах газар
- ЦДШ-ын алдагдлыг бууруулах арга хэмжээ, дүрэм, журмууд

5. Үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт

а/ программ хангамж

- богино залгааны гүйдлийн тооцооны программ

- статик тогтворжилтын тооцооны программ
- динамик тогтворжилтын тооцооны программ
- нейтральный горимын тооцоо
- цахилгаан станцуудын хооронд ачаалал хуваарилах горимын программ
- холбоо мэдээллийн системийн схем, журам
- үйл ажиллагааг хянах магнитофон
- ЦДШ-ын урт, тоо хэмжээ, нэвтрүүлэх чадвар
- ЦДШ-ын тогтворжилтын нөхцлөөр дамжуулах чадлын хязгаар
- ЦДШ-д тавигдсан реле хамгаалалт, автоматик
- ЦДШ-ын тооцооны дэлгэмэл схем г.м
 - б/ холбоо, мэдээллийн хэрэгслэл
 - в/ системийн аваари устгах хэрэгслэл /тавигдсан автоматикүүд, тэдгээрийн тавил тооцоо, аваарийн бичлэг хийх хэрэгслэл г.м./
 - г/ Мөрдөгдөх хууль эрхийн актууд /диспетчерийн төвийн дүрэм, системийн дүрэм, аж ахуйн харилцааны дүрэм, үйлдвэрлэх, дамжуулах, цахилгаан импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй хийсэн гэрээнүүд г,м

6. Үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл

- Цахилгаан сүлжээний эзэмшлийн заагийг харуулсан бүрэн схем, /220/110/35 кВ/
- Цахилгаан сүлжээний тооцооны схем
- Цахилгаан сүлжээний байршлын схем

7. Санхүүгийн нөөц, эдийн засгийн чадавхи

- Байгууллага, компаний санхүү, хөрөнгийн нөөц, чадавхи, эдийн засгийн үйл ажиллагаа, гадаад дотоод зээл, өр, авлага зэргийн талаархи мэдээлэл, судалгаа
- Эрхлэх үйл ажиллагааны тариф, ашиг алдагдлын тооцоо

8. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага.

Эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр ажиллах ажилтнуудын орон тоо, цалингийн сан, мэргэжил, боловсрол, тухайн чиглэлээр ажилласан хугацаа, дадлага, туршлага, мэргэшсэн байдлын талаархи судалгаа, мэдээлэл

Цахилгаан дамжуулах тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн агуулга

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ. /нотариатаар батлуулан хавсаргана./

Тухайн компанийн танилцуулга байх бөгөөд түүнд үүсэл хөгжил, бүтэц зохион байгуулалт, өмчийн хэлбэр, эрхлэдэг үйл ажиллагааны төрлүүд, үйлчилгээний хүрээ, гаднын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хийгдэх байгаа буюу хийгдэхээр төлөвлөгдөж байгаа төслүүд, санхүү хөрөнгийн нөөц, өр авлага, эдийн засгийн үзүүлэлтүүдийг харуулсан схем зураг, хүснэгт маягтын хэлбэрээр хийж үйл ажиллагааны бусад онцлогуудыг тусгасан байна.

2. Техник, эдийн засгийн үндэслэлд дараахь зүйлийг заавал тусгасан байна.

- а/ цахилгаан дамжуулах зайлшгүй шаардлага Үүнд:
 - цахилгаан дамжуулах сүлжээний үйлчлэх хүрээ, схем
 - үйлдвэрлэгч, түгээгчийн байршил
 - б/ цахилгаан дамжуулах үйл ажиллагаа эрхлэх боломж
 - дадлага, туршлага
 - техник хэрэгслэл, машин механизм

- хууль эрхийн актуудыг бүрдүүлсэн байдал
- Эрчим хүчний тухай хууль, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг судласан байдал
- Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан гэрээ хэлцлүүд г.м
в/ дамжуулалтын зардлын тооцоо
г/ цахилгаан дамжуулах үйл ажиллагааны орлого, зарлага, ашиг, алдагдлын тооцоо

3. Дамжуулах цахилгааны төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт

- дамжуулах цахилгааны тоо хэмжээ, чадлын баланс
- дамжуулах сүлжээний техникийн алдагдлын судалгаа /хүчдэлийн түвшингээр/
- Системийн хүчдэлийн түвшинг тохируулах хэрэгслэл, хүчдэл тохируулах арга, дүрэм, журам, зааврууд
- Дамжуулах сүлжээний техникийн алдагдлыг бууруулахтай холбоотой дүрэм, журмууд

4. Үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт

- дамжуулах сүлжээний үндсэн тоноглолын техникийн үзүүлэлтүүд
- систем үүсгэгч ЦДШ-ын тогтворжилтын нөхцлөөр дамжуулах чадлын хязгаар
- ЦДШ-д тавигдсан реле хамгаалалт, автоматик
- Дамжуулах сүлжээний зааг дээр тавигдсан хэмжих хэрэгслэл /тоолуурын төрөл, нарийвчлал, тавигдсан огноо/, тооцох аргачлал, схем, зураг;
- ЦДШ-ын бусад ЦДШ, холбооны шугам, авто ба төмөр замтай огтолцсон цэгүүд /байршлаар/
- Дамжуулах сүлжээний алдагдлыг бууруулах техник хэрэгслэл, тооцооны программ хангамж, алдагдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

5. Үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл

- Цахилгаан сүлжээний эзэмшлийн заагийг харуулсан бүрэн схем, /220/110/35 кВ/
- Цахилгаан сүлжээний тооцооны схем
- Цахилгаан сүлжээний байршлын схем

6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Цахилгаан дамжуулах шугам нь хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж буй эсэх талаар холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэлгээ хийлгэсэн байна.

7. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дээрхи байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах хөрөнгө, хариуцах эзэнтэйгээр гаргаж өргөдөлд хавсаргана.

8. Санхүүгийн нөөц, эдийн засгийн чадавхи

- Байгууллага, компаний санхүү, хөрөнгийн нөөц, чадавхи, эдийн засгийн үйл ажиллагаа, гадаад дотоод зээл, өр, авлага зэргийн талаархи мэдээлэл, судалгаа
- Эрхлэх үйл ажиллагааны тариф, ашиг алдагдлын тооцоо

9. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага.

Эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр ажиллах ажилтнуудын орон тоо, цалингийн сан, мэргэжил, боловсрол, тухайн чиглэлээр ажилласан хугацаа, дадлага, туршлага, мэргэшсэн байдлын талаархи судалгаа, мэдээлэл

Цахилгаан импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн агуулга

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ /нотариатаар батлуулан хавсаргана./

Компанийн танилцуулга байх бөгөөд түүнд үүсэл хөгжил, бүтэц зохион байгуулалт, өмчийн хэлбэр, эрхлэдэг үйл ажиллагааны төрлүүд, үйлчилгээний хүрээ, гаднын хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хийгдэх байгаа буюу хийгдэхээр төлөвлөгдөж байгаа төслүүд, санхүү хөрөнгийн нөөц, өр авлага, эдийн засгийн үзүүлэлтүүдийг харуулсан схем зураг, хүснэгт маягтын хэлбэрээр хийж үйл ажиллагааны бусад онцлогуудыг оруулсан байна.

2. Техник, эдийн засгийн үндэслэлд дараахь зүйлийг заавал тусгасан байна.

а/ Цахилгаан импортлох, экспортлох шаардлага,

- тухайн компанийн техникийн ба санхүүгийн боломж,
- эрх бүхий байгууллагаас тогтоосон импортлох цахилгааны тоо, хэмжээ
- цахилгаан импортлох ба экспортлох тухай талуудтай хийсэн гэрээ
- Импорт, экспортын үйл ажиллагааг зохицуулахтай холбогдох диспетчерийн төвтэй байгуулсан аж ахуйн гэрээ,
- Импорт, экспортын цахилгааны алдагдлыг хуваарилах, тооцоог хийхтэй холбогдон дамжуулах сүлжээтэй байгуулсан гэрээ буюу протоколыг хавсаргана.
- Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан гэрээ хэлцлүүд
- Цахилгаан импортлох, экспортлох үйл ажиллагааны зардлын тооцоо
- үйл ажиллагааны ашиг, алдагдлын тооцоо.

3. Импортлох, экспортлох цахилгааны төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт

- сүүлийн ба хүлээгдэж байгаа 5 жилийн ЭХС-ийн чадал, хэрэглээний баланс
- импортлох, экспортлох цахилгааны чадал, тоо хэмжээ, гэрээний үнэ, шугамын алдагдал, дамжуулалтын өртөг, төлбөрийн байдал
- цахилгаан импортлох, экспортлох үйл ажиллагааг хянах тооцооны хэрэгслэл, тооцоо хийх аргачлал
- үндсэн сүлжээний хүчдэлийн түвшинг хэвийн барих талаар авах техникийн ба зохион байгуулалтын арга хэмжээ

4. Үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт

- ЦДШ ашиглах талаар байгуулсан гэрээ, эсвэл ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлтүүд
- Тавигдсан автомат, хамгаалалт, холбооны хэрэгслэл
- ЦДШ-ын тооцооны дэлгэмэл схем
- үйл ажиллагаанд мөрдөх хууль эрхийн актууд /2 талын ажиллах заавар, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх бусад ТЗЭ-тэй хийсэн гэрээнүүд г,м /

5. Санхүүгийн нөөц, эдийн засгийн чадавхи

- Байгууллага, компаний санхүү, хөрөнгийн нөөц, чадавхи, эдийн засгийн үйл ажиллагаа, гадаад дотоод зээл, өр, авлага зэргийн талаархи мэдээлэл, судалгаа
- Эрхлэх үйл ажиллагааны үнэ, тариф, ашиг алдагдлын тооцоо

7. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага.

Эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр ажиллах ажилтнуудын орон тоо, цалингийн сан, мэргэжил, боловсрол, тухайн чиглэлээр ажилласан хугацаа, дадлага, туршлага, мэргэшсэн байдлын талаархи судалгаа, мэдээлэл

Цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн агуулга

1. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл

Өргөдлийг Хавсралт 11-д заасан маягийн дагуу гаргана.

2. Улсын бүртгэлийн гэрчилгээ

Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар батлуулж ирүүлнэ. Гэрчилгээнд байгууллага, компанийн тухай танилцуулгыг хавсаргах бөгөөд танилцуулгад байгууллага, компаний үүсэл хөгжил, үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, боловсон хүчний хангалт, өмчийн хэлбэр, эрхэлдэг бусад үйл ажиллагааны төрлүүд зэргийн талаар тодорхой тусгасан байна.

3. Техник, эдийн засгийн үндэслэл

- тухайн байгууллага, компани нь тодорхой нутаг дэвсгэр, эзэмшлийн хүрээнд цахилгаан, дулаан түгээх үйл ажиллагаа эрхлэх техник-эдийн засгийн боломж
- цахилгаан, дулаан түгээх үйл ажиллагаа эрхэлснээр олох орлого, зарлага, ашиг, алдагдал зэргийн талаар өнөөгийн түвшинд эдийн засгийн тооцоо судалгаа хийсэн байна.

4. Түгээх эрчим хүчний төрөл хэмжээ, чанарын үзүүлэлт

- өөрийн эзэмшлийн шугамаар түгээх цахилгаан, дулааны эрчим хүчний хэмжээ, тэдгээрийн чанарын үзүүлэлтүүд (хүчдлийн түвшин, давтамж, даралт, температур г.м.)
- цахилгаан, дулааны эрчим хүчний чанарын үзүүлэлтийг хангахгүй байгаа шугам, дэд өртөө, насос станцууд болон хэрэглэгчдийн судалгаа
- хэрэглэгчдийн эрчим хүчний хангамжийг техникийн шалтгаанаар тасалсан тоо, хязгаарласан эрчим хүчний хэмжээ
- түгээх шугам сүлжээний цахилгаан, дулаан дамжуулах, түгээх чадлын хязгаар зэргийн талаар дэлгэрэнгүй судалгаа, мэдээлэл гаргана.

5. Үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт

Дараахь судалгаа, мэдээллийг гаргана. Үүнд:

- цахилгаан, дулааны шугамын урт, техникийн алдагдал (шугамын хүчдэл/голчийн хэмжээ бүрээр);
- дэд өртөө, дулаан хуваарилах төв, насос станц зэргийн хүчин чадал, тоо, техникийн алдагдал (хүч чадлын түвшин бүрээр)
- шугам, дэд өртөө, дулаан хуваарилах төв, насос станц болон бусад тоног төхөөрөмжүүдийн ашиглалтын өнөөгийн байдал
- дамжуулах болон бусад түгээх шугам сүлжээнүүдийн эзэмшлийн зааг дээр тоолуур, хэмжих хэрэгсэл тавьсан эсэх, тоолуураар хэрэглэгчдийг хангасан байдал, тоолуур, хэмжих хэрэгсэлийн техникийн үзүүлэлтүүд, тэдгээрийн ашиглалтын байдал
- түгээх шугамын горим, алдагдал, богино залгааны гүйдэл зэргийг тооцох программ хангамжууд, телемеханик, холбоо мэдээллийн хэрэгсэл зэргээр хангагдсан байдал
- шугамын утас, тулгуур гэх мэт тоног төхөөрөмж, сэлбэгийн аюулгүйн нөөц

- ашиглалт, засвар үйлчилгээнд хэрэглэх машин механизм, тоног төхөөрөмжийн судалгаа

6. Үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл

- цахилгаан, дулаан түгээх үйл ажиллагаа эрхэлж буй харьяалах нутаг дэвсгэр, эзэмшлийн зааг ба эдгээрийг харуулсан зураг, схем
- түгээх сүлжээний зарчмын болон байршлын схем
- Цахилгаан станцууд болон дамжуулах, түгээх (бусад) шугам сүлжээний газруудаас авсан болон хэрэглэгчдэд түгээсэн цахилгаан, дулааны эрчим хүчний тэнцэл зэргийн талаарх мэдээлэл, судалгаа

7. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Шугамын орчин, хамгаалалтын зурвас зэрэг нь хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж буй эсэх талаар үнэлэлт өгсөн байна.

8. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэж байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж ирүүлнэ.

9. Санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи

Байгууллага, компаний санхүү, хөрөнгийн нөөц, чадавхи, эдийн засгийн үйл ажиллагаа, гадаад дотоодын зээл, өр, авлага зэргийн талаарх мэдээлэл, судалгаа

10. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага

Байгууллага, компанид эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр ажиллах ажилтнуудын мэргэжил, боловсрол, тухайн чиглэлээр ажилласан хугацаа, дадлага, туршлага, мэргэшсэн байдлын талаарх судалгаа, мэдээлэл

Цахилгаан, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн агуулга

1. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл

Өргөдлийг Хавсралт 11-д заасан маягтийн дагуу гаргана.

2. Улсын бүртгэлийн гэрчилгээ

Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар батлуулж ирүүлнэ. Гэрчилгээнд байгууллага, компанийн тухай танилцуулгыг хавсаргах бөгөөд танилцуулгад байгууллага, компаний үүсэл хөгжил, үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, өмчийн хэлбэр, боловсон хүчний хангалт, эрхлэдэг бусад үйл ажиллагааны төрлүүд зэргийн талаар тодорхой тусгасан байна.

3. Техник эдийн засгийн үндэслэл

- тухайн байгууллага, компанийн цахилгаан, дулаанаар хангах үйл ажиллагаа эрхлэх боломж

- цахилгаан, дулаанаар хангах үйл ажиллагаа эрхэлснээр олох орлого, зарлага, ашиг, алдагдал зэргийн талаар өнөөгийн түвшинд эдийн засгийн тооцоо судалгаа хийсэн байна.

4. Хангах эрчим хүчний төрөл хэмжээ, чанарын үзүүлэлт

- цахилгаан станцууд болон дамжуулах, түгээх (бусад) шугам сүлжээний газруудаас худалдан авсан цахилгаан, дулааны эрчим хүчний хэмжээ, тэдгээрийн чанарын үзүүлэлтүүд (хүчдлийн түвшин, давтамж, даралт, температур г.м.)
- цахилгаан, дулааны эрчим хүчний чанарын үзүүлэлтийг хангахгүй байгаа шугам, дэд өртөө, насос станцууд болон хэрэглэгчдийн судалгаа
- хэрэглэгчдийн эрчим хүчний хангамжийн тасалдлын тоо, хязгаарласан эрчим хүчний хэмжээ зэргийн талаар дэлгэрэнгүй судалгаа, мэдээлэл гаргана.

5. Үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт

- дамжуулах болон бусад түгээх шугам сүлжээнүүдийн эзэмшлийн зааг дээр тоолуур, хэмжих хэрэгсэл тавьсан эсэх, тоолуураар хэрэглэгчдийг хангасан байдал
- тоолуур, хэмжих хэрэгсэлийн техникийн үзүүлэлтүүд, тэдгээрийн ашиглалтын байдал
- борлуулалтын төлбөр тооцооны систем, түүнийг автоматжуулсан байдал, түгээх шугамын техникийн алдагдал зэргийн талаарх судалгаа, мэдээлэл;

6. Үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл

- цахилгаан, дулаанаар хангах (борлуулах) үйл ажиллагаа эрхэлж буй харьяалах нутаг дэвсгэр, эзэмшлийн зааг ба эдгээрийг харуулсан зураг, схем
- эрчим хүчний хангалт хийхэд ашиглаж буй түгээх сүлжээний зарчмын болон байршлын схем
- хэрэглэгчдийн бүтэц, ангилал (ахуйн хэрэглэгчид, төсвийн байгууллагууд, үйлдвэр аж ахуйн газрууд г.м), тэдгээрийн эрчим хүчний хэрэглээ, хэрэглэгчидтэй байгуулах гэрээний нөхцөл, шаардлагууд;
- цахилгаан станцууд болон дамжуулах, түгээх (бусад) шугам сүлжээний газруудаас худалдан авсан болон хэрэглэгчдэд борлуулсан цахилгаан, дулааны эрчим хүчний тэнцэл
- эрчим хүчний худалдааны (арилжааны) алдагдалыг хэрэглэгчдийн байршил, шугамын фидер зэргээр ангилж гаргах

7. Санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи

Байгууллага, компаний санхүү, хөрөнгийн нөөц, чадавхи, эдийн засгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд, гадаад дотоодын зээл, өр, авлага зэргийн талаарх мэдээлэл, судалгаа;

8. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага

Байгууллага, компанид эрчим хүчээр хангах үйл ажиллагааны чиглэлээр ажиллах ажилтнуудын мэргэжил, боловсрол, тухайн чиглэлээр ажилласан хугацаа, дадлага, туршлага, мэргэшсэн байдлын талаарх судалгаа, мэдээлэл;

Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн агуулга

1. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл

Өргөдлийг Хавсралт 11-д заасан маягтийн дагуу гаргана.

2. Улсын бүртгэлийн гэрчилгээ. /нотариатаар батлуулан хавсаргана./

Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар батлуулж ирүүлнэ. Гэрчилгээнд байгууллага, компанийн тухай танилцуулгыг хавсаргах бөгөөд танилцуулгад байгууллага, компаний үүсэл хөгжил, үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, өмчийн хэлбэр, боловсон хүчний хангалт, эрхлэдэг бусад үйл ажиллагааны төрлүүд зэргийн талаар тодорхой тусгасан байна.

3. Техник, эдийн засгийн үндэслэл

- Эрчим хүчний барилга байгууламж барих геологи хайгуулийн зураг төсөл, тооцоо,
- Байгууламжийн техникийн зураг, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтууд,
- Хөрөнгө оруулалтын өгөөж, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа
- Тухайн байгууллага, компани нь тодорхой нутаг дэвсгэр, эзэмшлийн хүрээнд эрчим хүчний барилга байгууламж барих техник-эдийн засгийн боломж.
- Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаа эрхэлснээр олох орлого, зарлага, ашиг, алдагдал зэргийн талаар өнөөгийн түвшинд хийсэн эдийн засгийн тооцоо судалгаа.
- Барилга байгууламжийн зураг төсөл, барилга байгууламжийн зураг төсл, барилга угсралтын ажлыг эрх бүхий байгууллагаар гүйцэлгүүлж хянуулсан байна.

4. Эрчим хүчний төрөл хэмжээ, чанарын үзүүлэлт

- Үйлдвэрлэх болон дамжуулах, түгээх цахилгаан, дулааны эрчим хүчний хэмжээ, тэдгээрийн чанарын үзүүлэлтүүд (хүчдлийн түвшин, давтамж, даралт, температур г.м.)
- Түгээх шугам сүлжээний цахилгаан, дулаан дамжуулах, түгээх чадлын хязгаар зэргийн талаар дэлгэрэнгүй судалгаа, мэдээлэл гаргана.

5. Үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт

- Эрчим хүчний барилга байгууламж барихад шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмжийн жагсаалт, төрөл марк, техникийн тодорхойлолт.

6. Үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл

- Тухайн эрчим хүчний барилга байгууламжийн нутаг дэвсгэр, эзэмшлийн зааг ба эдгээрийг харуулсан зураг, схем
- Уг байгууламжийн үйлдвэрлэх, дамжуулах, түгээх дулаан, цахилгааны эрчим хүчний хөгжлийн урт хугацааны хэрэглээний тэнцэлийн судалгаа, мэдээлэл.

7. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Барилга байгууламжийг барих явцад хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөлийг хийсэн ерөнхий үнэлгээнээс гадна нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн байна.

8. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэж байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, зарцуулах хөрөнгийг тооцож ирүүлэх.

9. Санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи

Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн санхүүгийн чадавхи, уг төслийг хэрэгжүүлэх хөрөнгийн нөөцийг баталгаажуулсан байх төдийгүй, гадны хөрөнгө оруулалтаар хэрэгжих бол санхүү зээлийн эх үүсвэрийн мэдээллийг хавсаргана.

10. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага туршлага

Эрчим хүчний барилга байгууламжийн барьж байгуулах эрх бүхий гүйцэтгэгчийн ажлын туршлага, ажилтнуудын мэргэжил, боловсрол, тухайн чиглэлээр мэргэшсэн байдлын талаарх судалгаа, мэдээлэл.

1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн маягт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

Тусгай зөвшөөрөл хүсэх тухай өргөдөл гаргах нь:

..... аймаг, хотын сум, дүүргийн хорооны нутаг дэвсгэрийн гудамжны байрлах оноосон нэртэй манай байгууллага “Эрчим хүчний тухай” Монгол Улсын хуулийн дагуу үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсч энэ өргөдлийг гаргав.

Манай компани дээр дурдсан үйл ажиллагааг явуулах техникийн болон санхүүгийн бүрэн чадавхитай ба уг үйл ажиллагааг явуулах нөхцөл, шаардлагыг хангасан ба тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай баримт бичгийг үнэн зөв гаргаж, энэхүү өргөдөлд хавсаргав.

Олгосон зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулахдаа “Эрчим хүчний тухай”, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” Монгол улсын хуулиуд, тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл, шаардлага, бусад хууль тогтоомж, эрх зүйн актуудыг чанд сахин биелүүлж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн хүндэтгэх болно.

Асуудлыг хүлээн авч шийдвэрлэж өгнө үү?

ӨРГӨДӨЛ ГАРГАСАН:

ДАРГА /ЗАХИРАЛ/...../тайлал/
/гарын үсэг/

ЕРӨНХИЙ /АХЛАХ/
НЯГТЛАН БОДОГЧ...../тайлал/
/гарын үсэг/

Шуудангийн хаяг:.....
Харилцах утас.....
Факс.....
И мэйл